



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 55

Мандалговь

**Х.Оюунчимэгийг Нийгмийн даатгалын хэлтсийн  
Дэлгэрцогт сумын Нийгмийн даатгалын байцаагчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн Дэлгэрцогт сумын Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Хад овогтой Оюунчимэг 62.6 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Х.Оюунчимэгийн холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Нийгмийн даатгалын хэлтсийн Дэлгэрцогт сумын  
Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд  
нэр дэвшүүлсэн Х.Оюунчимэгийн тухай дүгнэлт**

1. Х.Оюунчимэг нь 1976 онд Дундговь аймгийн Өндөршил суманд төрсөн. 46 настай, эмэгтэй
2. Боловсрол: 1995-1999 онд Цагаан лавай багшийн дээд сургуулийг Монгол хэл, уран зохиолын багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2020-2021 онд Дэлгэрцогт сумын ЗДТГ-т нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан.
4. Х.Оюунчимэгийн тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Нийгмийн даатгалын хэлтсийн Дэлгэрцогт сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

